



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 1 дүгээр сарын 16-ны  
өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 23 2019 ОНЫГ “ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ” БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласугай.
2. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
3. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын сайд,

Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга

Г.ЗАНДАНШАТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 2/30

Хүрэмт

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгох тухай 2019 оны 23 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батцэцэг- ЗДТГазрын дарга

Нарийн бичгийн дарга: Ж.Долгорсүрэн- Иргэний танхимын ажилтан

Гишүүд: Д.Энхбаатар- ЭМТөвийн дарга

Ц.Хоролмаа- ЕБСургуулийн захирал

Х.Должинсүрэн- Цэцэрлэгийн эрхлэгч

Т.Лхагважав- Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Ууганбаяр- Туяа багийн ЕБСургуулийн захирал

Ш.Элбэгжаргал- ИТХурлын нарийн бичгийн дарга

Т.Бямбасүрэн-1-р багийн Засаг дарга

П.Давгадорж- 2-р багийн Засаг дарга

Д.Баасандорж- 3-р багийн Засаг дарга

Э.Баянмөнх- 4-р багийн Засаг дарга

А.Мягмарням -5-р багийн Засаг дарга

С.Чинзориг- 6-р багийн Засаг дарга

2. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган, үр дүнг улирал бүр нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Х.Батцэцэг  
Х.ДАШДЭЛЭГ

# 2019

## ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ

